



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2021 оны 03 сарын 26-ны
өдөр хүлээн авсан.

2021 оны 3 сарын 11 өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.9 дэх хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Цагдаагийн ерөнхий газар болон Харилцаа холбооны зохицуулах хорооноос ирүүлсэн саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам"-ын 1 дүгээр зүйлийн "журмаар" гэсний дараа "Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.7," гэж, 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн "ойлгомжтой," гэсний дараа "нээлттэй" гэж, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн "хангуулах" гэсний дараа "ажлын" гэж, 5.3 дахь хэсгийн "ажиллах" гэсний дараа "эрх бүхий" гэж, 5.5 дахь хэсгийн "мэдээллийг" гэсний дараа "нэн" гэж, 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтын "46.11 дэх" гэсний дараа "хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.8, 42.11 дэх" гэж, 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтын "сонгуулийн" гэсний өмнө "Улсын Их хурал болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн" гэж, 3, 6 дугаар бүлэгт дор дурдсан агуулгатай 3.2, 3.7, 6.3.3 дахь заалтыг тус тус нэмсүгэй.

"3.2. Нам, эвсэл, нэр дэвшигч нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт заасны дагуу сонгуулийн сурталчилгаанд цахим хуудас ашиглах тохиолдолд Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлнэ.

3.7. Цахим үйлчилгээ эрхлэгч нь сонгуулийн сурталчилгаа явуулах тохиолдолд сонгуулийн сурталчилгаа эхлэхээс 3-аас доошгүй хоногийн өмнө Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлнэ.

6.3.3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим хуудсыг Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлэх;"

2. Мөн 1 дүгээр хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.5 дахь хэсгийг "Гүний цахим хуудас /Deep Web/-наас бусад бүх төрлийн контентийг хэрэглэгчид хүргэдэг веб сайт, цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудас (пэйж хуудас) нь энэ журмын үйлчлэлд хамаарна." гэж өөрчлөн найруулсугай.

3. Мөн 1 дүгээр хавсралтын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийн "хуудаст" гэснийг "хуудас сонинд" гэж, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн "санал" гэснийг "эрх

00000068

бүхий албан тушаалтны шийдвэр бүхий албан бичиг" гэж, 4.3, 4.4 дэх хэсгийн "санал гэснийг" "албан бичиг" гэж, 4 дүгээр зүйлийн 4.4, 4.5, 4.6, 4.6.1, 4.8, 3 дугаар зүйлийн 6.2, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3 дахь хэсгийн "интернетэд суурилсан" гэснийг "цахим" гэж, 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийн "шуудан хаяг, факсаар" гэснийг "хэлбэрээр" гэж өөрчилсүгэй.

4.Мөн 1 дүгээр хавсралтын 3 дугаар зүйлийн "3.2, 3.2.1, 3.2.2, 3.2.3, 3.3, 3.4, 3.5" гэсэн дугаарыг "3.3, 3.3.1, 3.3.2, 3.3.3, 3.4, 3.5, 3.6" гэж өөрчилсүгэй.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН



1117 153152

9128719
УХА0306

П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА ӨЧИР